



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/133

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам"-ын 3.6.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2024 оны төсөв батлах тухай" 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор төвлөрсөн хогийн цэгийн хог байгальд тархахаас сэргийлэх ажлын зардалд 12,289,580 (арван хоёр сая хоёр зуун наян есөн мянга таван зуун ная) төгрөгийг зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Зардалд шаардагдах 12,289,580 (арван хоёр сая хоёр зуун наян есөн мянга таван зуун ная) төгрөгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.


4.Байгаль хамгаалах сарын аяны хүрээнд зохион байгуулсан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

Сумын Засаг даргын 2024 оны
6 дугаар сарын 13-ны өдрийн А/133
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



**ХӨРСНИЙ ДОРойТЛОос УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР
ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГИЙН ХОГ БАЙГАЛЬД ТАРХАХААС
СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Арга хэмжээний ажил, хэрэглэгдэх зүйлсийн нэр	Хэмжих нэгж тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
	1	2	3	4
1	Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор төвлөрсөн хогийн цэгийг байгальд тархахаас сэргийлэх материал бэлтгэх	100	15,122	1,512,200
2	Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор төвлөрсөн хогийн цэгийг байгальд тархахаас сэргийлэх шатахууны зардал	2844	3,790	10,777,380
3	Нийт дүн			12,289,580

---oOo---